



Барилгын политехник коллежийн
Захирлын 20 жилийн харалтадаа 15.-ны өдрийн
А/б. 9 дугаартай тушаалын хавсралт

УХДНЭСЛЭЛ 9889322

Багш, ажилтан, ажилчдыг шагнаж, урамшуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь мэргэжлийн боловсролын талаарх бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, соёл, барилгын салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан Барилгын политехник коллежид ажиллаж байгаа болон ажиллаж байсан багш, ажилтан, ажилчдын бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллуулах, сайшаан урамшуулахад оршино.
- 1.2. Барилгын политехник коллежид ажиллаж байгаа болон ажиллаж байсан багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулахдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засгийн газар, салбар яамдын шагналаар шагнах журмууд болон энэхүү журмыг баримтална.

Хоёр. Шагналын төрөл

- 2.1. Монгол улсын цол, төрийн дээд одон медаль
- 2.2. Засгийн газрын болон салбар яамдын шагнал
- 2.3. Байгууллагын шагнал. Дараах төрөлтэй байна.
 - 2.3.1. “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж алдаршуулах
 - 2.3.2. “Оны тэргүүн”-ээр шалгаруулах, дараах төрөлтэй байна.
 - 2.3.2.1. “Оны тэргүүний багш”
 - 2.3.2.2. “Оны бүтээлч ажилтан”
 - 2.3.2.3. “Оны тэргүүний ажилтан” /Захиргаа, сургалтын албанаас 1 ажилтан, үйлчилгээнээс 1 ажилчин/
 - 2.3.2.4. “Оны тэргүүний анги”
 - 2.3.2.5. “Оны тэргүүний тэнхим”
 - 2.3.2.6. “Оны тэргүүний суралцагч”
 - 2.3.3. Захирлын нэрэмжит шагнал олгох

Гурав. Шагналад тодорхойлох

- 3.1. Үр бүтээлтэй ажиллан тодорхой амжилт гаргасан, холбогдох байгууллагын шагналын дүрэм, журамд заасан болзолыг хангасан багш ажилтныг тодорхойлно.
- 3.2. Багш нарыг харьяа тэнхимийн хамт олны хурлаар, /ирц 75%-иас доошгүй, 80%-аас дээш дэмжсэн байх/
- 3.3. Ажилтан, ажилчдыг харьяалах албаны хамт олны хурлаар, /ирц 75%-иас доошгүй, 80%-аас дээш дэмжсэн байх/

- 3.4. БПК-д ажиллаж байсан багш, ажилчдыг нийт хамт олны хурлаар. /ирц 75%-иас доошгүй, 80%-иас дээш дэмжсэн байх/
- 3.5. Шагналын шалгуур ханган байгууллагаас тодорхойлогдсон ажилтны материалыг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, хүний нөөцийн ажилтан холбогдох байгууллагуудад журамд заасан хугацаанд хүргүүлнэ.
- 3.6. Байгууллагын шагналд нэр дэвшигчийн материалыг нэгжүүд харьяалах албаддаа хүргүүлж, алба хариуцсан менежерүүд 2-оос доошгүй нэр дэвшигчийн материалыг тэмдэглэлт өдөр, ой болохоос 2 долоо хоногийн өмнө Захиргааны зөвлөлд хүргүүлж, хурлаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Шагнал олгох болзол

- 4.1. Нэр дэвшигчийг Засгийн газрын шагналаар шагнагдсан бол Монгол Улсын одон, медалиар шагнуулахаар, Монгол Улсын одон, медалиар шагнагдсан бол Монгол Улсын цол хүртээхээр тус тус нэр дэвшүүлнэ.
- 4.2. Нэр дэвшигч нь “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, Засгийн газар, салбар яамдын шагналын журмуудын болзолыг хангасан байна.
- 4.3. Байгууллагын шагналын болзолд;
 - 4.3.1. **“Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж алдаршуулах**
 - Тухайн байгууллагад 15 ба түүнээс дээш жил ажилласан байх
 - Онцгой амжилт гаргасан
 - 4.3.2. **“Оны тэргүүний багш”**
 - Сургалтын арга зүй, чанар, гүйцэтгэл
 - Суралцагчидтай ажилласан байдал
 - Хувь хүний хөгжил, манлайлал
 - Сургалтын орчин бүрдүүлсэн байдал
 - Олон нийтэд үзүүлсэн үйлчилгээ
 - Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал
 - 4.3.3. **“Оны бүтээлч ажилтан”**
 - Шинээр санаачлан хэрэгжүүлсэн оюуны болон биет бүтээл
 - 4.3.4. **“Оны тэргүүний ажилтан” /ажилтан 1, ажилчин 1/**
 - Тайлант жилийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэсэн ажил
 - Шинэ санал санаачилга гаргаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үр дүнд хурсэн байдал
 - Хувь хүний хөгжил, манлайлал
 - Ажлын байрны зохион байгуулалт, эмх цэгц
 - Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал
 - 4.3.5. **“Оны тэргүүний анги”**
 - Сурлагын амжилт, чанар
 - Цаг ашиглалт
 - Анги танхимын тохижилт

- Хамт олноос хэв журмын болон ёс зүйн зөрчил гаргаагүй байх
- Сургуулиас зохиосон соёл хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцсон байх
- Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тооны харьцааны индекс

4.3.6. “Оны тэргүүний суралцагч”

- Сүүлийн 2 улирал дараалан “А” үнэлгээтэй суралцсан
- Мэргэжил, урлаг, спортын амжилт гаргасан байх
- Олон нийтийн ажилд суралцагчдыг тэргүүлэн оролцдог байх

4.3.7. Захирлын нэрэмжит шагнал олгох

- Сургуулийг хөгжүүлэх үйлсэд идэвхи санаачлага гарган, үр бүтээлтэй ажиллаж, байгууллагад бодит хувь нэмэр оруулсан байдал.

4.3.8. “Оны тэргүүний тэнхим”

- Сургалтын ажлын чанар, гүйцэтгэл
- Шинээр санаачилж хэрэгжүүлсэн бүтээлч ажил
- Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал, манлайлал
- Олон нийтэд чиглэсэн ажил, үйлчилгээ
- Ажлын байрны зохион байгуулалт эмх цэгц
- Хэв журам, ёс зүйн зөрчилгүй байх

Тав. Шагналыг дагалдах мөнгөн дүнгийн хэмжээ

5.1. Монгол улсын цол, төрийн дээд одон медалаар шагнагдсан багш, ажилтан мөн 15-аас дээш жил ажилласан ахмад настанд дараах байдлаар шагналыг дагалдах мөнгөн урамшуулалт олгоно.

- 5.1.1. Монгол улсын Гавьяат ба түүнээс дээш, 500.000 төгрөг
- 5.1.2. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, 400.000 төгрөг
- 5.1.3. Алтан гадас одон 300.000 төгрөг
- 5.1.4. Хөдөлмөрийн хүндэт медаль 200.000 төгрөг

5.2. Засгийн газрын болон салбар яамдын шагнал

- 5.2.1. Тэргүүний ажилтан цол тэмдэг, 100.000 төгрөг
- 5.2.2. Хүндэт жуух бичиг, 50.000 төгрөг

5.3. Байгууллагын шагнал

- 5.3.1. “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж алдаршуулахад 400.000 төгрөг /тууз, өргөмжлөл/
- 5.3.2. “Оны тэргүүн”-д 300.000 төгрөг /тууз, өргөмжлөл/
- 5.3.3. Захирлын нэрэмжит шагналад 300.000 төгрөг /тууз, өргөмжлөл/
- 5.3.4. “Оны тэргүүний тэнхим”-д 1.000.000 төгрөг /шилжин явах цом/

Зургаа. Урамшуулалт олгох

6.1. Дэлхийн ажил мэргэжлийн олимп-д оролцох эрх олгодог “Монгол ур чадвар” улсын уралдаанд амжилттай оролцсон бол дараах байдлаар урамшуулна.

1-р шатанд

	Багш	Суралцагч
6.1.1. Тэргүүн байр	1 сарын үндсэн цалингийн 50%	300,000₮
6.1.2. Дэд байр	1 сарын үндсэн цалингийн 40%	250,000₮
6.1.3. Гутгаар байр	1 сарын үндсэн цалингийн 30%	200,000₮
6.1.4. Дөрөвдүгээр байр	1 сарын үндсэн цалингийн 20%	150,000₮
6.1.5. Тавдугаар байр	1 сарын үндсэн цалингийн 10%	100,000₮

2-р шатанд

6.1.6. Тэргүүн байр	1 сарын үндсэн цалин	500,000₮
6.1.7. Дэд байр	1 сарын үндсэн цалингийн 80%	400,000₮

3-р шатанд

6.1.8. Тэргүүн байр	1 сарын үндсэн цалингийн 150%	1,000,000₮
---------------------	-------------------------------	------------

6.2. Дэлхийн ур чадварын тэмцээнд амжилттай оролцож медальт байранд шалгарсан тохиролдолд эксперт багшид 1 сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, суралцагчийг 2 сая төгрөгөөр шагнаж урамшуулна.

Долоо. Шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх

7.1. Байгууллагын шагналаар шагнагдах оны тэргүүнүүдийн урамшууллыг Захирлаар тушаалаар олгоно.

-----000-----